



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2018 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/379

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд  
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх  
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дах хэсэг, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам"-ын 2.17 дах заалт, Монгол Улсын Засгийн Газар, Люксембургийн Их Гүнт Улсын засгийн газар хооронд 2017 оны 06 дугаар сард байгуулсан "Монгол Улсын Зүрх Судасны Үндэсний Төв ба зүрх судасны тусламж үйлчилгээг уялдуулан сайжруулах нь МОН/006" төслийн гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох  
2 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.

2. Зөвшөөрлийн гэрчилгээг бичиж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайд  
 2018 оны 08 сарын 15-ны өдөр  
 Агаар дугаар гүйцээлийн хавсралт



МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ  
 ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,  
 ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

Овог нэр	Харьяалал	Ажиллах байгууллага	Гэрчилгээний сөри/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1. Шарпентьер Арнауд Францойз Паскал Charpentier Arnaud Francois Pascal	Люксембург ийн Их Гүнт Улс	Улсын Гуравдугаар Төв Эмнэлэг	ГЭ0002123	Цээжний ба зүрхний мэс засал судлал	Эмчлэх	2018.10.02-2018.10.08 хоног/
2. Биллауд Филлиппе Жэйн Ричард Billaud Philippe Jean Richard	Бүгд Найрамдах Франц Улс	Улсын Гуравдугаар Төв Эмнэлэг	ГЭ0002124	Цээжний ба зүрхний мэс засал судлал	Эмчлэх	2018.10.02-2018.10.08 хоног/